

ГАНДАНДАШГЭМПИЛ ИХ НОМЫН ХИЙДИЙН ХУВРАГУУДЫН АВЧ ГЭЭХИЙГ ЁСЧЛОН ҮЙЛДЭХ ЦААЗ ОРШВОЙ

(mKhan chin choi kyī rgyal po'I gsung 'bum las\ Choi sde chen po dga 'ldan
bkrashes dge 'phel gyi dge 'dunrnams kyī spang blang rnams tshul
bshin du bgyi ba'I khrim su btsas ba bzhugs so)

Төвд хэлнээсорчуулсан Б. Цэвээндорж –МУИС. НШУС. Шашин судлалын тэнхим, магистрант

Ум сайн амгалан болтугай. Ариун тойн, хамгийг айлдагч Богд гүнчин Банчиндоржчан, шавь лугаа сэлтийн өлмийд мөргөмүй. Их энэрэлээр цаг хийгээд ахуй үес бүхэнд даган барин соёрх.

Энэ их номын аймаг Гандандашгэмпилд орших хувараг тойдын авах гээхийн ёсыг үйлдсэний зарлиг цаазанд ер олохуйяа бэрх эрдэнэт хүний биеийг олоод уулзахуйяа бэрх бурхны шашин лугаа учирснаар барахгүй, тойны энэ цагт чөлөө учралын тусад үйлдэх хэрэгтэй.

Түүнээ ер ганцхан шашны ангид тонилохын санваар мөн тул өөр өөрийн тойн, гэцэл, гэлэнгийн сахилыг асар ариунаар, сайтар сахих хэрэгтэй.

Зарлигаас: Ёс цааз цалгайрваас муу заяанд одох бөгөөд түүнийг олонтоо сонссоноор аврагдаж чадахгүй хэмээн номлосон. Тиймээс их хөлгөний аймаг савд номлосончлон бодьсавын суртгаал тэргүүтэнд шамдаж үйлдэгтүн. Дандарын дөрвөн их аймаг лугаа барилдуулсан хот мандалд авшиг аваад үндэс унал тэргүүтнээр эс халдаж үйлдээд судар тарнийг хослуулан барилдуулсныг анхааран авч шамдах хэрэгтэй. Энэ нь тонилохыг огоот хүсэгчдэд эхэнд нь магадтай хэрэглэх өчүүхэн өгүүлэл болох болой.

Энэ дацанд оршсон хуварагууд бээр орон ахуй үедээ нийцүүлэн эн тэргүүнд тойны авах гээхийн ёсон болоод уншлагыг сайтар судалж түүнээс итгэл явуулан туурвиж хурлын чуулганд уншлагын номт явдал тэргүүтэн ариун явдал бүхнийг бариад багш хийгээд хуралд шалгуулах. Дараа нь авшиг, даган соёрхол, эш нугуудыг сайтар аваад Сандуй, Дэмчигдилвү лха аа, Доржжигжэд, Гүнрэг, Минтэг, Цэвэгмид Лхагвү зэргийн зан үйлийг гүйцэт төгсгөгтүн. Гомбо, Чойжал, Лхам, Шалши, Шанлон, Намсрай, Жамсран нугуудын уншлага тэргүүтнийг огоот төгсгөгтүн. Тэдгээрийн гарын авлага, мутрын зан үйл, цан хэнгэрэг тэргүүтний ая данд суралцаж, ялангуяа энэ дацанд Дэмчигийг эрхэмд зохиосон тул түүний үүсгэл төгсгөлийн зэрэг, бясалгал бүтээл, өөрт орох, машид оршоох, гал мандал, чуулганы хүрд нугуудыг сайтар хөтлөн хичээгтүн. Машид амирласан ба номхорсон, шашин хийгээд дацанд сүсэглэх их бишрэлтэй, сэтгэл таалалд нийцүүлсэн, ариун ёстой нэгэн хэрэгтэй.

Тэвчин үйлдэх нь: Ер доройтол хийгээд язгуурын уналаар эс халдмой. Гурван санваартаа харшлах ер ба ялангуяа архины гэм бүхний үндэс мөн тул алагдах аминд тулсан ч цээрлэх хэрэгтэй болой. Хүнийг алах тэргүүтний доройтол бодит суурийг үйлдвээс хуврагийн хамаг эд хэрэгсэл нь нийтийн эд болон хурж, шадар оршигч лугаа сэлт нь холдоно. Архи ууваас зуун удаа манж барьж, нэг сайн тэмээ, хоёр сайн морь авч гэрчид тушаана. Орон цагийн эрхээр хуралд ханцуйтай хүрэм тэргүүтнийг өмсөвч улаан, шар өнгөнөөс өөрийг өмсөх хийгээд сахал үс нь ихтэй. Хонины арьсан малгай тэргүүтэн үзэмжгүй зүйл, малгай, жанч, орхимж үгүй хийгээд өөрийн цайны аягагүй увшаас дээш сахилтай хүмүүс номын дээлгүй тэргүүтэн болвоос ном ёсоор шинжээд хорин нэгэн удаа

мөргүүл. Хийдэд хэрүүл тэмцэл гаргаваас зуун удаа мөргүүл. Сүм дуган хийгээд хуралд тэмцвээс зуун удаа манж бариулах хийгээд мөргүүл. Хуралд дэмий үг ярих хийгээд их дуугаар дуудах ба аньсгүй чуулах хийгээд босож явах тэргүүтэн зохисгүй тэргүүтэн гаргаваас арав мөргүүл. Их гүрэм заслыг тавихад дара эхийг нэг удаа өнгөрөөхөд хүрвээс долоон удаа мөргүүл, долоон удаа өнгөрөөвөөс хорин нэг мөргүүл. Судрыг айлтгалгүй хуралд хүрвээс тавин удаа мөргүүл. Нэг өдөр гүрэм тасалваас арав мөргүүл, хоёр өдөр гүрэм тасалваас нэг зуун тавь мөргүүл, гурван өдөр гүрэм тасалваас нэг зуу мөргүүлж, тавин зул өргүүл, дөрвөн өдөр гүрэм тасалваас нэг зуу мөргүүлж, нэг зуун зул өргүүл, таван өдөр гүрэм тасалваас нэг зуу мөргүүлж, нэг зуун тавин зул өргүүл, зургаан өдөр гүрэм тасалваас хоёр зуу мөргүүлж, нэг зуун тавин зул өргүүл, долоон өдөр гүрэм тасалваас манж барих хийгээд тавь мөргүүлж, тавин зул өргүүл, найман өдөр гүрэм тасалваас манж барих хийгээд хоёр зуун тавь мөргүүлж, хоёр зуун тавин зул өргүүл, есөн өдөр гүрэм тасалваас манж барих хийгээд хоёр зуу мөргүүлж, хоёр зуун наян зул өргүүл, арваас дээш өдөр гүрэм тасалваас байнга манж өргүүлэх сэлт хийгээд гурван зуу мөргүүлж, хоёр зуун удаа зул өргүүлж, таван лан мөнгийг байнга жасад тушаа.

Цайны үеэр эхлээд лавай үлээхэд гарч ирэн үүдний дэргэд Мэгзэм тэргүүнийг айлдаж, гуравдахь удаагаа лавай үлээхэд дотор залраад хөгшин залуугийн эрэмбээр суудалдаа эндүүрэлгүй сууж, гэсгүй бээр эхлээд хүж эргүүлж утлага хүжийг уугиулж үйлдэнэ. Түүний дараа цайны үед хоёрдахь удаагаа хүж эргүүлэх лугаа цайг бэлдэнэ. Гэсгүй бээр цайгаа соёрхон өчихөд цайг таалаад эхлээд хурал унших ба өглөгийн эзэн ирэх аваас өглөгийн эзэн хийгээд байхгүй боловоос цайны дараа гуравдахь удаагаа хүж эргүүлнэ. Түүний дараа өчүүхэн цайны үед дөрөвдөх удаагаа хүжийг үйлдэж бага зэрэг цайг өчиж тэгш агуулж ерөөл байваас өргөж, жич бас цай байваас яруу сонсож чуулганд үг өчих хэрэг байваас өчөөд лам бээр ерөөл үйлдмүй. Зэд байваас түгээж лавай татаад, зэдээ өгнө. Тавдахь удаагаа сайхан үнэрт хүжийг уугиулж үйлдээд сайхан үнэрийг алгуур аажмаар үнэртүүлмүй. Зэд, лавайг тавиад тодорхой зорилгод эс хүрвээс эздийн хувийг эс өгмүй. Лаврон хийгээд жасын тулд өгөгч нугууд ба өвчтөн хийгээд ажилчидад эздийн хувийг өгмүй. Лаврон хийгээд ловон багш, номын цаазтан хийгээд өглөгийн эзнээс ангид хүмүүс цайнаас хүртэхгүй.

Соёрхол, айлтгал хэрэг нугуудыг нэг өдөрт гэсгүйд айлтгана. Түүнээс дээш өдөр бол лам гэсгүй хоёуланд айлтгана. Түүгээр өчүүхэн хэрэгт ч соёрхолыг султгахгүй. Дацангийн их бага үйл үйлдвэр аль нь ч лам номын цаазтан хийгээд өвгөд нугууд бээр зөвшилцөн тогтож үйлдэнэ. Үүнд эс өгүүлсэн нугуудыг гэсгүй бээр хамаарах үл хамаарахыг шинжилж үйлд.

Ерөнхийд нь хурааваас бурхан бээр ганцхан шашинд санаад энэ насны бэрх хэцүүг харгалзалгүй хожим хойдод орогчдод муу замд зорчилгүй Бурханы шашин өнө удаан оршихын арганд хуварагуудыг үнэхээр шамдан зохиолгож, ялангуяа лам ба гэсгүй тэргүүтэн үйлийг үүрэгч хэмээгч нугууд бээр машид өөрсдөө хянамгайлан зохиож үйлд. Тэдгээр лам хийгээд чухаг дээд гуравын эрхэнд зохиож шашны сахиусуудад өргөл хүндлэлийг тавьснаар мэдэгчилэн ялангуяа алах цааз бичгээс харшилтугай. Харшлагчлан цааз бичгийг эс үйлдэгч нугууд шашныг сахиж нийт хийгээд ялангуяа их ягчис бэгз ах дүү хийгээд билгэ билгийн дагинас, Сэнгэдомбожан бээр машид хатуу үйлээр гэсгээгтүн.

Сүм хийдүүд уншлага ба амны уншлагыг сайтар дэлгэрүүлэн уншуултугай. Үргэлжид хуварагууд эвтэй байх хийгээд хуврагийн хэрэг ч бүттүгэй хэмээсэн цааз бичиг үүнийг Номын ёст Лэгшаджамц бээр дурдсаны товч. Дацангийн үйлс хийгээд хөгшин залуу шавь суралцагчдын оюунд нийцүүлэн зөвшөөл олгов. Их Банчиндоржчангийн

дотны шавийн доод бурханы тойн Лувсан нэрт номлосноор үйлдсэн болой. Өлзий хутаг орштугай, сайн буян арвижих болтугай.